



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Замын-Үүдийн дулааны станц ТӨҮГ-ын 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан хураангуй тайлан

Аудитын код: ДГА-2023/08/НА-СТА-ТӨА

Цахим хуудас:
www.audit.mn
Сайншанд сум
2023 он

Дарга, тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий

Утас: 7052-2734

Цахим хаяг: Gan-Ulziit@audit.gov.mn

Аудитын менежер: У.Оюунтүлхүүр

Утас: 7052-3020

Цахим хаяг: Oyuntulkhuur.u@audit.gov.mn

Аудитор: Ч.Хэрлэнчимэг

Утас: 7052-3020

Цахим хаяг: Kherlenchimegch@audit.gov.mn

Аудитор: М.Дүүрэнжаргал

Утас: 7052-3020

Цахим хаяг: Duurenjargalm@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Нэг.Хараат бус аудиторын санал дүгнэлт



ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гудамж,
3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103,
Утас: (705) 2-27-34

Цахим хуудас: domogovi@audit.gov.mn

2023.03.15 № 1-6/334

танай _____-ны № _____-т

ЗАМЫН-ҮҮДИЙН ДУЛААНЫ СТАНЦ
ТӨҮГ-ЫН ЗАХИРАЛ О.ТӨМӨРХУЯГ
ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Замын-Үүдийн дулааны станц төрийн өмчит үйлдвэрийн газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Замын-Үүдийн дулааны станц ТӨҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тус газрын санхүүгийн үндсэн үзүүлэлт нь батлагдсан зорилтот түвшинд хүрээгүй байна. Үүнд, нийт 5,649.3 сая төгрөгийн орлогын гүйцэтгэлтэй ажиллаж, төлөвлөгөөнөөс 655.5 сая төгрөгөөр буюу 10.4 хувиар тасарсан. Энэ нь тус суманд тайлант онд ашиглалтад орж, дулааны эрчим хүчээр хангагдахаар төлөвлөсөн зарим байгууллагын барилга хэрэглэгч байгууллагын хүсэлтээр 2022 оны 12 дугаар сараас хэсэгчлэн дулааны эрчим хүчээр хангагдаж эхэлсэнтэй холбоотой байна.

Тус газар нийт 6,745.8 сая төгрөгийн зардлын гүйцэтгэлтэй ажиллаж, төлөвлөгөөнөөс 441.4 сая төгрөг буюу 7 хувиар зардал хэтэрсэн байна. Энэ нь эргэлтийн бус хөрөнгийн элэгдлийн зардлыг 163.9 сая төгрөгөөр төлөвлөсөн боловч гүйцэтгэлээр 1,771.6 сая төгрөгийн зардал тооцож, тус зардлыг 1,607.8 сая төгрөгөөр хэтрүүлж зарцуулсантай холбоотой байна.

Аудитын гол асуудал

010000458

Тус газрын санхүүгийн тайланд элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 31 нэр төрлийн 256.7 сая төгрөгийн анхны өртөг бүхий 6,859 ширхэг хөрөнгө бүртгэлтэй байна.

Тайлант онд хөрөнгө, мөнгө зарцуулсан нийт 830.0 сая төгрөгийн 53 шийдвэрээс 577.3 сая төгрөгийн 45 хөрөнгийн шийдвэрийг шилэн дансны системд байршуулаагүй байна

Бусад асуудлын хэсэг

Тайлант онд тус байгууллага орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, хөгжлийн сангаар Замын-Үүд суманд хийгдсэн дулааны болон бохирын шугам шинээр барьж, байгуулах 499.6 сая төгрөгийн 2 тендерийн ажилд шалгарч, гүйцэтгэсэн байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.ГАН-ӨЛЗИЙ

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан, төгрөгөөр

Мөрийн дугаар	Балансын зүйл	Үлдэгдэл	
		1 сарын 1	12 сарын 31
1.1.01	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	620,320,572.27	1,167,520,028.07
1.1.02	Дансны авлага	592,310,076.99	378,202,945.72
1.1.03	Татвар, НДШ-ийн авлага	14,065,223.46	10,046,296.33
1.1.04	Бусад авлага	99,857,153.28	72,617,967.34
1.1.06	Бараа материал	910,652,169.40	969,669,243.79
1.1.07	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	5,788,139.47	37,306,184.74
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	2,242,993,334.87	2,635,362,665.99
1.2.01	Үндсэн хөрөнгө	56,174,991,451.28	71,475,468,507.78
1.2.02	Биет бус хөрөнгө	18,433,793.20	24,986,370.23
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	56,193,425,244.48	71,500,454,878.01
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	58,436,418,579.35	74,135,817,544.00
2.1.1.01	Дансны өглөг	8,133,724.57	8,750,036.58
2.1.1.03	Татварын өр	5,265,022.97	20,453,144.78
2.1.1.08	Урьдчилж орсон орлого	2,694,903.00	2,200,000.00
2.1.1.12	Бусад	1,580,341.44	1,040,035.11
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	17,673,991.98	32,443,216.47
2.2	Өр төлбөрийн нийт дүн	17,673,991.98	32,443,216.47
2.3.01	Өмч: - төрийн	58,447,078,331.66	75,256,227,787.78
2.3.06	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	-	19,112,120.17
2.3.09	Хуримтлагдсан ашиг	(28,333,744.29)	(1,171,965,580.42)
2.3.09.1	Тайлангийн үеийн ашиг	-	(1,096,552,891.89)
2.3.09.2	Өмнөх үеийн ашиг	(28,333,744.29)	(75,412,688.53)
2.3.11	Эздийн өмчийн дүн	58,418,744,587.37	74,103,374,327.53
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	58,436,418,579.35	74,135,817,544.00

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан, төгрөгөөр

Мөрийн дугаар	Балансын зүйл	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
01	Борлуулалтын орлого (цэвэр)	1,674,527,887.75	4,372,163,413.10
02	Борлуулалтын өртөг	2,977,949,026.74	5,934,921,374.32
03	Нийт ашиг(алдагдал)	1,303,421,138.99	(1,562,757,961.22)
05	Хүүний орлого	-	26,849,315.07
08	Бусад орлого	1,580,879,705.78	1,250,258,053.71
08.1	Орлогын дүн	1,580,879,705.78	1,277,107,368.78
09	Борлуулалт, маркетингийн зардал	-	-
10	Ерөнхий ба удирдлагын зардал	305,337,940.08	806,894,716.40
12	Бусад зардал	161,900.00	4,007,583.03
12.1	Зардлын дүн	305,792,311.08	810,902,299.43
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	(0.02)
17.1	Олз, гарзын дүн	-	(0.02)
18	Татвар төлөхийн өмнөх ашиг(алдагдал)	(28,333,744.29)	(1,096,552,891.89)
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(28,333,744.29)	(1,096,552,891.89)
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(28,333,744.29)	(1,096,552,891.89)

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан, төгрөгөөр

Үзүүлэлт	Өмч	Хөр-н дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2020 оын 12 сарын 31-ээр үлдэгдэл	56,223,853,722.97	-	-	-	56,223,853,722.97
НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	2,223,224,608.69	-	-	-	2,223,224,608.69
Залруулсан үлдэгдэл	-	-	-	-	-
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	(28,333,744.29)	(28,333,744.29)
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-	-
2021 оын 12 сарын 31-ээр үлдэгдэл	58,447,078,331.66	-	-	(28,333,744.29)	58,418,744,587.37
НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	16,809,149,456.12	-	-	-	16,809,149,456.12
Залруулсан үлдэгдэл	-	-	-	(75,412,688.53)	(75,412,688.53)
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	(1,096,552,891.89)	(1,096,552,891.89)
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-
Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-	-
Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	19,112,120.17	-	-	19,112,120.17
2022 оын 12 сарын 31-р үлдэгдэл	75,256,227,787.78	19,112,120.17	-	(1,171,965,580.42)	74,103,374,327.53

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан, төгрөгөөр

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	3,393,062,627.55	6,771,641,960.85
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	1,803,068,603.07	5,493,274,885.08
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	1,460,584,370.00	700,000,000.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	129,409,654.48	578,367,075.77
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	2,624,811,355.28	5,992,032,232.32
1.2.1	Ажиллагчдад төлсөн	623,982,267.00	1,817,755,777.80
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	207,429,934.99	588,647,132.35
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	1,244,257,046.62	1,641,204,865.67
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	105,309,091.07	382,971,048.95
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	144,765,255.00	249,789,610.00
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	-	3,580,367.35
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	163,456,337.14	709,553,804.00
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	-	2,411,981.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	135,611,423.46	596,117,645.20
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	768,251,272.27	779,609,728.53
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	147,930,700.00	232,410,272.73
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	134,070,700.00	219,683,000.01
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	13,860,000.00	12,727,272.72
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(147,930,700.00)	(232,410,272.73)
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	620,320,572.27	547,199,455.80
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	620,320,572.27
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	620,320,572.27	1,167,520,028.07

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
<i>Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт гол нэр төрлөөр:</i>					
1	а/ Дулаан үйлдвэрлэлт	мян.Гкал	92	59	(33)
	б/ Улсын төсвийн татаас	төгрөг	700,000,000.00	636,363,636.36	(63,636,363.64)
	в/ Бусад орлого /алданги торгуулийн засвар үйлчилгээний орлогууд/	төгрөг	700,000,000.00	640,743,732.40	(59,256,267.60)
2	Нийт орлого	төгрөг	6,304,821,473.20	5,649,270,781.86	(655,550,691.34)
	Үүнээс: Цэвэр борлуулалт	төгрөг	4,904,821,473.20	4,372,163,413.10	(532,658,060.10)
3	Нийт зардал	төгрөг	6,304,430,110.84	6,745,823,673.75	441,393,562.91
	Үүнээс: Удирдлагын зардал	төгрөг	83,020,350.00	79,603,083.06	(3,417,266.94)
4	Татварын өмнөх ашиг /алдагдал/	төгрөг	391,362.36	(1,096,552,891.89)	(1,096,944,254.25)
5	Цэвэр ашиг, алдагдал	төгрөг	352,226.12	-	(352,226.12)
6	Төсвийн төлбөрт нийт дүн	төгрөг	1,011,521,700.00	1,298,200,900.00	286,679,200.00
7	Төрийн өмчийн ногдол ашигт	төгрөг	-	-	-
8	Нийт ажиллагсдын тоо	хүн	172	141	(31)
9	Нийт цалингийн сан	төгрөг	2,226,269,850.00	2,057,117,817.00	(169,152,033.00)
10	Нэг ажиллагчийн дундаж цалин	төгрөг	1,060,455.96	1,215,790.67	155,334.71
11	Нэгж бүтээгдэхүүний өртөг ДЭХ	төгрөг	68,520,247.43	114,335,994.47	45,815,747.04
12	Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	төгрөг	1.00	1.19	0.19
13	Хөрөнгө оруулалт	төгрөг	150,674,500.00	126,100,734.00	(150,548,399.30)
14	Нийт авлага	төгрөг	420,000,000.00	460,867,209.39	40,867,209.39
15	Нийт өглөг	төгрөг	-	32,443,216.47	32,443,216.47
	Үүнээс: Богино хугацаат	төгрөг	-	1,040,035.11	1,040,035.11

Гурав. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 16.7 сая төгрөгийн зөрчил¹ илэрснээс, 16.7 сая төгрөгийн 1 албан шаардлага хүргүүлж, үнийн дүнгүй 2 зөвлөмж өгсөн. Аудитаар алдаа илрээгүй болно.

3.1 Албан шаардлага

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасны дагуу тус газар нь дэд захирлын орон тоонд өөрчлөлт оруулж, хассан байна. Гэвч ТӨБЗГ-ын 2022 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн тогтоолоор Захиргаа, санхүү удирдлагын хэлтсийн даргын 1 орон тоог шинээр бий болгосон байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4-т “Энэ хуульд заасныг зөрчиж тэргүүн дэд, дэд, орлогч дарга, зөвлөхийн чиг үүрэгтэй ижил эрх, үүрэг бүхий өөр нэршилтэй албан тушаалын орон тоо бий болгох, түүнд аливаа албан тушаалтныг томилох, орон тоог хэвээр хадгалахыг хориглоно” гэж заасныг зөрчсөн.

Шинээр бий болсон Захиргаа, санхүү удирдлагын хэлтсийн даргын албан тушаалд тус газрын захирлын 2022 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн Б/164 дүгээр тушаалаар албан хаагчийг томилсон ба 7 дугаар сараас 12 дугаар сард нийт 16.7 сая төгрөгийн цалин хөлсийг олгосон байна.

3.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт: Тус газрын санхүүгийн тайланд элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 31 нэр төрлийн 256.7 сая төгрөгийн анхны өртөг бүхий 6,859 ширхэг хөрөнгө бүртгэлтэй байна. Энэ нь ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 7.1, 7.2-т заасныг зөрчсөн байна.

Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн хөрөнгийн асуудлыг шийдвэрлэхгүй байх нь үндсэн хөрөнгийн бодит үнэлгээ дутуу илэрхийлэгдэх үр дагавартай.

1.2. Өгсөн зөвлөмж: Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 31 нэр төрлийн 256.7 сая төгрөгийн анхны өртөг бүхий 6,859 ширхэг хөрөнгийг дахин үнэлгээ тогтоох, актлах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж, холбогдох шатны байгууллагад хүсэлтийг хүргүүлэн, шийдвэрлүүлэх.

Дээрх үндсэн хөрөнгийн асуудлыг шийдвэрлэх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 10 дугаар сарын 15 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

2. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт: Тайлант онд хөрөнгө, мөнгө зарцуулсан нийт 830.0 сая төгрөгийн 53 шийдвэрээс 577.3 сая төгрөгийн 45 хөрөнгийн шийдвэрийг шилэн дансны системд байршуулаагүй байна. Мөн цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 7.5 сая төгрөгийн орлогын 1 гүйлгээ, 18.6 сая төгрөгийн зарлагын 1 гүйлгээг мэдээлээгүй байна. Уг зөрчил нь хэрэглэгчдийг мэдээллээр бүрэн хангахгүй байх үр дагавартай байна.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5-д “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ.. цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр”, 6.4.8-д “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ..бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

2.2. Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг бүрэн хангаж, шилэн дансны системд байршуулаагүй дээрх мэдээллийг нөхөн байршуулах.

Дөрөв. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/ Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгийн асуудлыг шийдвэрлээгүй	1	-					1	-				
Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 5.4 дэх заалтыг хэрэгжүүлээгүй	1	16,673.0			1	16,673.0						
Дүн	2	16,673.0			1	16,673.0	1	-				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/ Үүнээс						
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
Тухай бүр байршуулах мэдээллийг мэдээлээгүй	1	-						1	-
Дүн	1	-						1	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил									
Дүн	-	-						-	-
Нийт дүн	1	-						1	-

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс тагталзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ								
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
6	ТБОНӨААН	1	1			1			
	НИЙТ	1	1			1			